

2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

**ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД**

**Шинжээчээр хамтран ажиллах урилга хүргүүлэх тухай**

Үндэсний аудитын газар нь “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитад “**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим барилга, байгууламжийн зураг төсөл, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг хянаж, дүгнэлт гаргах /Улаанбаатар хот, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр аймаг/**” зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Шинжээч нь УАГ-АД/2022-042 дугаартай ажлын даалгаврын Хавсралт 1-д тусгагдсан 8 төсөл арга хэмжээний зураг төсөл, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг хянаж, дүгнэлт гаргах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

Шинжээч нь төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажилбаруудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Барилга, байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах;
- Барилга, байгууламжийн төсвийг батлагдсан зургийг үндэслэн, холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон дүгнэлт гаргах;
- Барилга байгууламжийн ажлыг магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- Барилга угсралтын ажилд гүйцэтгэгчийн дотоод хяналт болон захиалагч, зохиогч, техникийн хяналт хийсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;
- Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан байдалд дүгнэлт гаргах;
- Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад барилгын материалын орц, тоо хэмжээ, нэр төрөл, чанарыг хянаж, батлагдсан төсөв болон бодит гүйцэтгэлийн хооронд тоо хэмжээ, чанарын зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах;

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, барилга, байгууламжийн зураг төсөл, ажлын гүйцэтгэл, санхүүжилт нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудтай нийцсэн эсэх, барилга, байгууламжийг техникийн шаардлагын дагуу барьж ашиглалтад оруулсан эсэхийг хянан үзэж, гарсан үр дүн, үр нөлөөг тусгасан мэргэжлийн дүгнэлт бүхий тайланг бэлтгэн, гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Мэдүүлгээ ирүүлж буй хувь хүн/баг/, хуулийн этгээд нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээс илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ.

**Үүнд: Хуулийн этгээд бол:**

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт /цахимаас татан авсан/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/цахимаас татан авсан/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2020,2021, 2022 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 он/

**Хувь хүн/баг бол:**

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/:

Шинжээч нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төслийн эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, барилга, байгууламжийн зураг төсөл, магадлалын чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, барилга угралтын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргаж чадахуйц, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага туршлагатай, иргэн, хуулийн этгээд /түншлэл/ байх бөгөөд зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ. Үүнд:

- Багийн ахлагч:  
Барилгын инженер, Монгол Улсын зөвлөх инженер, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 12 ба түүнээс дээш жил ажилласан байх;

- Багийн гишүүд:  
Халаалт, агаар сэлгэлт, цахилгаан, холбоо, ус хангамж, ариутгах татуургын инженер, тэргүүлэх төсөвчин, мэргэшсэн инженер, мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан, судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 12 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 12 цаг 10 минутын дотор [tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn), [info@audit.gov.mn/](mailto:info@audit.gov.mn) цахим хаягаар pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,  
Засгийн газрын IV байр, 305 тоот өрөө. Үндэсний Аудитын газар. Утас: 51-261745.

[www.audit.mn](http://www.audit.mn)